

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
Г.ЧИНЗОРИГ ТАНАА

2020.03.13 № 06/865
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга Г.Чинзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглалт хэвийн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглагдах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтлөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцаж хэрэгжүүлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/240 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Монгол Улсын нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийг дэмжсэн харилцаа холбооны салбарын зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлээ “Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт шийдвэр гаргах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь УСНББОУС, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Acolous 3.0” программ хангамж ашигладаг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Харилцаа холбооны зохицуулах хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 10,619.4 сая төгрөгийн 2 хувиар тооцож 212.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,387.5 сая төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,150.8	17,510.8	5,360.0
Авлага	3,537.0	2,825.2	(711.8)
Урьдчилгаа	294.3	34.2	(260.1)
Бараа материал	13.1	10.5	(2.6)
Үндсэн хөрөнгө	6,111.9	6,113.9	2.0
Нийт хөрөнгө	22,107.1	26,494.6	4,387.5
Өр төлбөр	2,570.2	2,888.5	318.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	19,536.9	23,606.1	4,069.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	22,107.1	26,494.6	4,387.5

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнө оноос 5,360.0 сая төгрөгөөр нэмэгдэж 17,510.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь тусгай зөвшөөрлийн төлбөр гэрээний хугацаанд төлөгдөж байгаа, тусгай зөвшөөрлийн авлага 4,293.2 сая төгрөгөөр барагдсанаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 711.8 сая төгрөгөөр буурсан нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2000-2011 онуудад үүссэн, он удаан жил болсон 181.5 сая төгрөгийн хувь хүнээс авах 12 авлага байна. Үүнээс төлбөр төлөх боломжгүй, ажилгүй, тэтгэвэрт гарсан, нас барсан, холбоо барих боломжгүй зэрэг шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 181.5 сая төгрөгийн авлага байна.

Авлага дансны нийт 2,825.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасны 90.5 хувь буюу 2,555.8 сая төгрөг нь төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 903.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 250.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 318.3 сая төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орлого нэмэгдсэн, НҮБ-ийн хүүхдийн сангаас санхүүжин хэрэгжиж буй “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” төсөл он дамжин хэрэгжих болсноос шалтгаалжээ.

Өр төлбөр данс нийт 2,888.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасны 96.5 хувь буюу 2,788.7 сая төгрөг нь тусгай зөвшөөрлийн урьдчилж олсон орлого байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 23,606.1 сая төгрөг болж 4,069.2 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 16.9 сая төгрөгийн бичилт нь гэрээт ажлын гүйцэтгэлээрх буцаалт, хөрөнгийн дахин үнэлгээгээрх бүртгэлийг залруулсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо тайлант онд 6,293.7 сая төгрөгийн орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 10,619.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 168.7 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны буюу тусгай зөвшөөрлийн орлого 4,325.7 сая төгрөгөөр давсан нь гэрээнд заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөр төлөгдөж, 1955-1960/2145-2150 МГц радио давтамжийн дараа үеийн хөдөлгөөнт холбооны технологид ашиглах /4G/ эрхийн гэрээ шинээр хийгдэж төлбөрүүд төлөгдсөнөөс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 10,914.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 5,990.7 сая төгрөгийг урсгал зардалд, 624.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 4,300.0 сая төгрөгийг он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээнд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 5,600.8 сая төгрөгийг зарцуулж, хөрөнгө оруулалтын 17 төсөл, арга хэмжээнд 613.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2018-2019 онд он дамжин хийгдсэн хөрөнгө оруулалтын зардалд 290.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 7,584.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 7,404.7 сая төгрөгийн алдааг залруулж, 113.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 66.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Тайлант онд хорооны хурлын үйл ажиллагааны зардлыг 78.9 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 34.4 сая төгрөгөөр нийт 113.3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж санхүүгийн тайлагнал, өр төлбөр, орлого, зардалтай холбоотой нийт 7,404.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага 6 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар илэрсэн 66.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 121 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 19.6 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. *Бараа материал данстай холбоотой асуудал*

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 40.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээ хийлгэж, гэрээний дагуу хүлээн авсан судалгааны ажлын тайлан, ажлын баримт зэргийг шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", УСНББОУС 12-ын 9(б)-д "Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх, ашиглан залилан үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зөвлөх үйлчилгээ хийлгэж, гэрээний дагуу хүлээн авсан судалгааны ажлын тайлан, ажлын баримтыг бараа материалд бүртгэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

3.2.1. Илрүүлэлт:

Элэгдлийн зардлаараа анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 529.3 сая төгрөгийн анхны өртөгтэй 6 ширхэг авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлээгүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглалт хэвийн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглагдах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох асуудлыг холбогдох газарт нь хандаж шийдвэрлүүлэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 *Зардлын данстай холбоотой асуудал*

3.3.1. Илрүүлэлт:

Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд бусад байгууллагын гадаад томилолтын зардалд нийт 26.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг хэтрүүлэх, холбогдох журам зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,995,225,167.08	20,380,672,752.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,150,843,982.81	17,510,775,100.93
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,150,843,982.81	17,510,775,100.93
31210	Төгрөг	12,145,899,053.06	17,502,842,152.54
31213	Арилжааны банк дахь харилцах	12,145,899,053.06	17,502,842,152.54
31220	Гадаад валют	4,944,929.75	7,932,948.39
31223	Арилжааны банк дахь харилцах	4,944,929.75	7,932,948.39
33	АВЛАГА	3,537,020,961.27	2,825,184,140.69
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,313,650,601.86	2,555,865,512.71
33500	Бусад авлага	223,370,359.41	269,318,627.98
33510	Байгууллагаас авах авлага	39,001,376.98	74,965,749.21
33520	Хувь хүмүүсээс авах авлага	184,368,982.43	194,352,878.77
34	УРЬДЧИЛГАА	294,248,023.00	34,234,681.21
34600	Урьдчилж гарсан зардал	-	33,927,458.21
34710	Урьдчилгаа тооцоо	294,248,023.00	307,223.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	3,697,500.00	-
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	290,243,300.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	307,223.00	307,223.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,112,200.00	10,478,830.00
35400	Хангамжийн материал	13,112,200.00	10,478,830.00
35410	Бичиг хэргийн материал	2,796,400.00	692,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,906,000.00	5,733,250.00
35470	Бусад хангамжийн материал	409,800.00	4,053,180.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,111,854,246.84	6,113,964,355.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,111,854,246.84	6,113,964,355.72
39200	Биет хөрөнгө	4,238,346,112.31	4,244,600,123.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,923,602,610.00	2,015,139,599.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(44,606,028.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	733,158,853.71	978,158,853.71
39204	Хуримтлагдсан элэгдэл	(569,464,409.09)	(637,458,853.49)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,550,865,417.24	5,762,742,931.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,504,856,603.26)	(3,933,164,361.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	262,428,329.26	259,675,265.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(157,388,085.55)	(155,887,282.14)
39300	Биет бус хөрөнгө	1,873,508,134.53	1,869,364,232.02
39301	Програм хангамж	1,236,762,763.74	1,344,226,320.62
39302	Хуримтлагдсан элэгдэл	(772,731,629.21)	(884,339,088.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,409,477,000.00	1,409,477,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	22,107,079,413.92	26,494,637,108.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,570,186,732.16	2,888,472,602.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,570,186,732.16	2,888,472,602.00
41300	Өглөг	491,790,537.58	99,727,306.78
41360	Бусад өглөг	491,790,537.58	99,727,306.78
41361	Байгууллагад төлөх өглөг	484,018,772.94	93,266,780.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,771,764.64	6,460,526.01
41400	Урьдчилж орсон орлого	2,078,396,194.58	2,788,745,295.22
41440	Бусад урьдчилж орсон орлого	2,078,396,194.58	2,788,745,295.22
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,536,892,681.76	23,606,164,506.55

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51	Засгийн газрын хувь оролцоо	19,536,892,681.76	23,606,164,506.55
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,595,812,553.85	1,169,840,273.85
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	1,409,477,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	16,708,955,739.90	20,794,722,844.69
51210	Өмнөх үеийн үр дүн	14,485,392,661.76	16,725,944,939.90
51220	Тайлант үеийн үр дүн	2,223,563,078.14	4,068,777,904.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,124,388.01	232,124,388.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	22,107,079,413.92	26,494,637,108.55

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,478,891,154.35	10,619,412,866.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,478,891,154.35	10,619,412,866.63
120	Нийтлэг татварын бус орлого	8,478,891,154.35	10,619,412,866.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,478,891,154.35	10,619,412,866.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,721,042,932.49	10,001,070,202.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	757,848,221.86	618,342,664.62
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,977,541,574.06	6,550,468,687.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,977,541,574.06	6,548,500,287.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,615,499,232.10	6,237,981,155.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,389,309,805.01	2,901,340,346.88
210101	Үндсэн цалин	2,389,309,805.01	2,901,340,346.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	288,447,562.61	364,679,775.35
210201	Тэтгэврийн даатгал	192,865,087.07	248,593,893.94
210202	Тэтгэмжийн даатгал	24,101,895.88	29,246,340.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,108,428.71	23,235,792.55
210204	Ажилгүйдлийн даатгал	4,669,479.18	5,741,467.76
210205	Эрүүл мэндийн даатгал	47,702,671.77	57,862,280.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,609,669.06	67,918,519.00
210301	Гэрэл, цахилгаан	45,392,299.06	52,431,914.00
210302	Түлш, халаалт	11,750,000.00	-
210304	Байрны түрээс	13,467,370.00	15,486,605.00
2104	Хангамж, бараа материалын зардал	167,058,697.20	212,115,320.68
210401	Бичиг хэрэг	20,003,636.00	29,341,540.00
210402	Тээвэр, шатахуун	49,454,949.46	47,410,924.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,869,986.54	47,842,624.03
210404	Ном, хэвлэл	25,537,422.20	45,544,909.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,643,302.00	13,102,760.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал /ТӨҮГ/	16,549,401.00	28,872,562.73
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,263,630.00	62,208,799.45
210604	Урсгал засвар	36,263,630.00	62,208,799.45
2107	Томилолт, зочны зардал	216,263,754.31	237,737,537.62
210701	Гадаад албан томилолт	175,652,928.31	172,489,387.62
210702	Дотоод албан томилолт	35,646,933.00	55,403,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,963,893.00	9,844,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,240,734.07	1,135,604,118.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,125,960.75	25,340,094.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	12,724,205.11
210803	Даатгалын үйлчилгээ	-	8,122,136.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,261,328.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	176,000.00
210807	Газрын төлбөр	-	11,247,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	950,745.77	1,630,359.50

210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	53,547,324.00	57,240,284.80
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	117,458,135.54	225,508,453.14
210813	Бусад зардал /ТӨҮГ/	818,158,568.01	792,354,157.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,439,305,379.84	1,256,376,737.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	840,652,390.20	901,788,434.12
210904	Найдваргүй авлагын алдагдал	598,652,989.64	354,588,303.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,042,341.96	310,519,131.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	362,042,341.96	310,519,131.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	362,042,341.96	310,519,131.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,968,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,968,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,501,349,580.29	4,068,944,179.13
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	396,476.32	210,160.60
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	396,476.32	210,160.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	278,182,978.47	376,434.94
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	376,434.94
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	278,182,978.47	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,223,563,078.14	4,068,777,904.79

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,492,270,044.16	11,775,772,265.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,492,270,044.16	11,775,772,265.79
120	Нийтлэг татварын бус орлого	8,492,270,044.16	11,775,772,265.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,729,664,277.55	11,148,446,530.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,729,664,277.55	11,136,952,886.03
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	11,493,644.40
120009	Бусад орлого	762,605,766.61	627,325,735.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,452,904,065.46	5,600,835,621.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,452,904,065.46	5,600,835,621.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,063,481,763.78	5,266,236,104.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,340,819,194.57	2,896,223,757.28
210101	Үндсэн цалин	2,340,819,194.57	2,896,223,757.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,544,327.99	364,699,199.09
210201	Тэтгэврийн даатгал	188,362,885.33	258,298,050.29
210202	Тэтгэмжийн даатгал	23,545,360.67	27,357,830.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,836,288.53	12,189,704.85
210204	Ажилгүйдлийн даатгал	4,709,072.13	6,077,601.18
210205	Эрүүл мэндийн даатгал	47,090,721.33	60,776,011.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,029,669.06	67,056,799.00
210301	Гэрэл, цахилгаан	52,607,299.06	52,431,914.00
210304	Байрны түрээс	12,422,370.00	14,624,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	174,770,547.74	217,008,919.02
210401	Бичиг хэрэг	22,286,636.00	30,489,940.00
210402	Тээвэр, шатахуун	48,914,500.00	51,681,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,869,986.54	48,208,624.03
210404	Ном, хэвлэл	30,619,182.20	39,230,908.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,080,243.00	47,397,976.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,329,110.00	52,297,973.69
210604	Урсгал засвар	36,329,110.00	52,297,973.69
2107	Томилолт, зочны зардал	217,270,969.51	237,290,139.22
210701	Гадаад албан томилолт	177,329,956.51	176,161,156.22
210702	Дотоод албан томилолт	34,977,120.00	51,283,943.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,963,893.00	9,845,040.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	946,717,944.91	1,431,659,317.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,126,388.84	25,081,561.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	50,225,814.20
210803	Даатгалын үйлчилгээ	-	8,343,136.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,261,328.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	176,000.00
210807	Газрын төлбөр	-	11,247,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	950,745.77	1,630,359.50
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	927,640,810.30	1,333,694,017.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	389,422,301.68	334,599,516.80

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	19,751,400.00	24,080,385.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	19,751,400.00	24,080,385.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	369,670,901.68	310,519,131.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	369,670,901.68	310,519,131.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,039,365,978.70	6,174,936,644.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	606,410,970.62	815,205,773.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	606,410,970.62	815,205,773.00
2200	Дотоод эх үүсвэрээр	606,410,970.62	815,205,773.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	533,047,970.62	903,898,543.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	73,363,000.00	(88,692,770.00)
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(606,410,970.62)	(815,205,773.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	554,495.97	200,246.52
14	Бусад эх үүсвэр	554,495.97	200,246.52
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	554,495.97	200,246.52
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,433,509,504.05	5,359,931,118.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,717,334,478.76	12,150,843,982.81
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,150,843,982.81	17,510,775,100.93

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	14,746,942,007.29	16,031,414,049.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(261,549,345.53)	(261,549,345.53)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	14,485,392,661.76	15,769,864,704.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	117,492,619.62	-	117,492,619.62
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	1,425,972,280.00	-	-	1,425,972,280.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,223,563,078.14	2,223,563,078.14
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,595,812,553.85	232,124,388.01	16,708,955,739.90	19,536,892,681.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(16,495,280.00)	-	16,989,200.00	493,920.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,579,317,273.85	232,124,388.01	16,725,944,939.90	19,537,386,601.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	4,068,777,904.79	4,068,777,904.79
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,579,317,273.85	232,124,388.01	20,794,722,844.69	23,606,164,506.55

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/97/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Харилцаа холбооны зохицуулах хороо		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд зөвлөх үйлчилгээ хийлгэж, гэрээний дагуу хүлээн авсан судалгааны ажлын тайлан, ажлын баримт зэргийг шууд зардлаар бүртгэсэн байна.	40.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
2	Элэгдлийн зардлаараа анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 529.3 сая төгрөгийн анхны өртөгтэй 6 ширхэг автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
3	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд бусад байгууллагын гадаад томилолтын зардалд нийт 26.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	26.1	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
4	Тайлант онд хорооны хурлын үйл ажиллагааны зардлыг 78.9 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 34.4 сая төгрөгөөр нийт 113.3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.	113.3	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/129

Улаанбаатар хот

САГ- 2020 / 37 / САГ-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хорооны хурлын үйл ажиллагааны зардлыг 78.9 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 34.4 сая төгрөгөөр нийт 113.3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор арилгаж, биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, ерөнхий нягтлан бодогч Н.Халиунаа нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР


Б.ЭНХЖИН

ЗӨВШӨӨРСӨН:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА


Г.ЧИНЗОРИГ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ


Н.ХАЛИУНАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.